



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот


Г Удирдах зөвлөлийн дүрэм батлах тухай

Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.1 дэх заалт, “Боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 1.3 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын Их Сургуулийн Удирдах зөвлөлийн дүрэм”-ийг хавсралт ёсоор баталж, 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн даган мөрдсүгэй.

2. Дүрмийг шинэчлэн баталсантай холбогдуулан МУИС-ийн Удирдах зөвлөлийн 2008 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 08/01 тоот тогтоолоор баталсан “МУИС-ийн Удирдах зөвлөлийн дүрэм”-ийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА




Д.РЭГДЭЛ

## МУИС-ИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмээр МУИС-ийн удирдах зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулна.



1.2. Удирдах зөвлөл нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, боловсролын тухай хууль тогтоомж болон боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн үлгэрчилсэн дүрмийг үндэслэн боловсруулсан МУИС-ийн удирдах зөвлөлийн дүрмийг мөрдлөг болгоно.

### Хоёр. Удирдах зөвлөлийг байгуулах

2.1. МУИС-ийн удирдах зөвлөлийг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр үүсгэн байгуулагч, багш, суралцагч, төгсөгчийн төлөөллийг оролцуулан байгуулна.

2.2. Удирдах зөвлөл нь дарга, дэд дарга, гишүүдээс бүрдсэн 15 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй байна. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 51-60 хувь нь үүсгэн байгуулагчийн, бусад нь багш, суралцагч, төгсөгчийн төлөөлөл байна.

2.3. Удирдах зөвлөлийн төрийн төлөөллийг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.

2.4. Удирдах зөвлөл дэх багшийн төлөөллийг үндсэн орон тооны багш нарын 50-аас доошгүй хувийн ирцтэй хурлаас нууц санал хураалтаар сонгоно.

2.5. Суралцагчийн төлөөлөл нь сургуулийн Оюутны холбооны тэргүүн байна.

2.6. Төгсөгчийн төлөөллийг төгсөгчдийн байгууллага болон бүрэлдэхүүн сургуулийн төгсөгчдийн холбооны удирдлагын хурлаас сонгоно.

2.7. Удирдах зөвлөлийн гишүүдийг 3 жилийн хугацаагаар томилж эсхүл сонгох бөгөөд жил бүр зөвлөлийн бүрэлдэхүүний гуравны нэгийг шинэчилж болно. Томилсон, сонгосон төлөөллийг эргүүлэн татах, солих тухай үүсгэн байгуулагч болон уг төлөөллийг сонгосон байгууллага, хамт олны хурлын шийдвэр, гишүүний өөрийнх нь хүсэлтийг үндэслэн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж болно.

2.8. Удирдах зөвлөлийн дарга, дэд даргыг үүсгэн байгуулагчийн саналыг харгалзан 3 жилийн хугацаагаар зөвлөлийн гишүүдийн хурлаас ил санал хураалтаар сонгоно.

2.9. Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг багшийн төлөөллөөс удирдах зөвлөлийн хурлаар томилно.

### Гурав. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаа

3.1. Удирдах зөвлөл нь МУИС-ийн дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.2. Удирдах зөвлөл нь сургуулийн захирлыг томилох, чөлөөлөх саналыг үүсгэн байгуулагчид тавьж болно.

3.3. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал бөгөөд гишүүдийн 60-аас доошгүй хувийн ирцтэй тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно. Хэлэлцсэн асуудлаар тэмдэглэл хөтөлж, олонхын саналаар шийдвэр /тогтоол/ гаргана.

3.4. Удирдах зөвлөлийн дарга тогтоолд гарын үсэг зурж албажуулна. Удирдах зөвлөл нь тогтоол, тэмдэглэлийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд сургуулийн тэмдэг дарж баталгаажуулна.

3.5. Удирдах зөвлөлийн хурлыг жилд 2-оос доошгүй удаа хийнэ. Ээлжит бус хурлыг үүсгэн байгуулагчийн, удирдах зөвлөлийн даргын, эсвэл гишүүдийн 1/3-ээс доошгүй хувийн саналаар зарлан хуралдуулна. Сургуулийн захирал удирдах зөвлөлийг хуралдуулах асуудлаар санал гаргаж болно.

3.6. Удирдах зөвлөлийн хурлын товыг хурал болохоос 3-5 хоногийн өмнө зарлаж, нарийн бичгийн дарга хэлэлцэх асуудлын баримт бичгийн төслийг гишүүдэд хүргүүлнэ.

3.7. Удирдах зөвлөлийн хуралд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан сургуулийн захирал, орлогч захирал, сургалтын албаны дарга, ерөнхий /ахлах/ нягтлан бодогч, багш, суралцагчийн төлөөлөгчийг удирдах зөвлөлийн даргын шийдвэрээр оролцуулан санал, хүсэлт, тайлбарыг сонсож болно.

3.8. Удирдах зөвлөл өөрийн үйл ажиллагаанд туслах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулж болох бөгөөд түүнийг удирдах зөвлөлийн гишүүн ахална.

3.9. Удирдах зөвлөлийн дарга дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.9.1. Удирдах зөвлөлийг хуралдуулах хугацаа, хэлэлцэх асуудлыг үүсгэн байгуулагч, сургуулийн захиралтай тохиролцох, хурлыг удирдан зохион байгуулах, шийдвэрийг албажуулах, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авах;

3.9.2. Удирдах зөвлөлийн гишүүдэд ажил үүргийн хуваарь гарган хариуцуулах, биелэлтийг хянах, зөвлөх;

3.9.3. Удирдах зөвлөлийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын чиглэлийг тогтоох, төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих;

3.9.4. Үүсгэн байгуулагчийн бодлого, шийдвэрийг тайлбарлах, сурталчлах ажлыг зохион байгуулах;

3.9.5. Удирдах зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаа, оролцооны талаарх үнэлэлт, дүгнэлтийг тухайн төлөөллөө томилсон, сонгосон байгууллагад нь мэдэгдэх;

3.9.6. Удирдах зөвлөл үйл ажиллагаа явуулахад шаардагдах орчин нөхцөлөөр хангуулах;

3.10. Удирдах зөвлөлийн гишүүн дор дурдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.


3.10.1. Сургуулийн үйл ажиллагааны талаар шаардлагатай мэдээлэл, судалгаа авах;

3.10.2. Удирдах зөвлөлийн хуралд идэвхтэй оролцож, санал, дүгнэлт гаргах;

3.10.3. Удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх талаар холбогдох хүмүүст шаардлага тавих, тайлбар гаргуулах, хуралд асуудал оруулж хэлэлцүүлэх;



- 3.10.4. Сургуулийг хөгжүүлэх талаар удирдах зөвлөлөөс гаргасан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- 3.10.5. Хариуцсан ажил, үүрэг, даалгаврыг чанартай биелүүлж, зөвлөлийн хурал, даргад танилцуулах;



**Дөрөв. Удирдах зөвлөл, үүсгэн байгуулагчийн хамтын ажиллагаа**

4.1. Удирдах зөвлөл нь үйл ажиллагааныхаа явц, үр дүнг үүсгэн байгуулагчийн өмнө тайлагнана. Хэлэлцэх асуудлын талаар үүсгэн байгуулагчтай зөвшилцөж, холбогдох мэдээллээр ханган ажиллана.

4.2. Үүсгэн байгуулагчийн төлөөлөл нь түүний бодлого, чиг үүргийг хэрэгжүүлэх асуудлаар үүсгэн байгуулагчтай хамтран ажиллана.

4.3. Үүсгэн байгуулагч нь Удирдах зөвлөл дэх өөрийн төлөөллийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, шаардлагатай бол энэ дүрмийн 2.7-д заасны дагуу арга хэмжээ авна.

**Тав. Бусад зүйл**

5.1. МУИС-ийн санхүүгийн бодлого, стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, төсвийн орлогын бүрдэлт, зарцуулалтад хяналт тавих үүрэг бүхий орон төөны дотоод аудиторыг удирдах зөвлөлөөс томилж ажиллуулна. Шаардлагатай нөхцөлд мэргэжлийн байгууллагын туслалцаа авч болно.

5.2. Удирдах зөвлөл нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй.

5.3. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэргийн болон бусад зардлыг сургуулийн тухайн жилийн төсөвт тусган зарцуулна.

